



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/БМ

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны тэмцлийн ажил (23500 га, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан, Бугат, Орхон, Сэлэнгэ, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Булган сумдад)-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 1 багц (Хангал, Бугат сумдад 9130 га талбай)-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Грандфорест" ХХК-тай 309,000,000 (гурван зуун есөн сая) төгрөгөөр, 2-р багц (Орхон, Бүрэгхангай, Хишиг-Өндөр сумдад 8030 га талбай)-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Ойнтаксац" ХХК-тай 227,700,000 (хоёр зуун хорин долоон сая долоон зуун мянга) төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Б.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Б.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Грандфорест" ХХК-ийн захирал (Б.Жавхлантагс), "Ойнтаксац" ХХК-ийн захирал (Д.Баярзориг) нарт даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010288

Аймгийн Засаг даргын 2024. оны
04 дүгээр сарын 04-ний өдрийн А/24... дугаар
захирамжийн хавсралт



ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Д.Батцогт